

**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 1 А/26.

Улаанбаатар хот.

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх хэсэг, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалт, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалт, нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 3.4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан хамтарсан үзүүлэх сургалт зохион байгуулахыг нийслэлийн Онцгой байдлын газрын орлогч дарга, онцгой байдлын хурандаа /Д.Эрдэнэбаатар/, нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/ нарт даалгасугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Сургалтын төсөв болох 1.116.628 /нэг сая нэг зуун арван зургаан мянга зургаан зуун хорин найман/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг нийслэлийн Онцгой байдлын газрын орлогч дарга, онцгой байдлын хурандаа /Д.Эрдэнэбаатар/, нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/ нарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Н.УЛАМБАЯР

ТТБ4381 ☎9077073

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Э.БАТТУЛГА

УОА0453

Нийслэлийн Онцгой байдлын газар, Аялал жуулчлалын газрын даргын 2014 оны 05 сарын 09 ний өдрийн 1/18 тоот хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт



ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ТЕХНИКИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОСЛООС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД ХАМТАРСАН
СҮРГАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай зочид буудлын барилга байгууламж, үйлчлүүлж буй гадаад, дотоодын иргэд, жуулчдын эрүүл аюулгүй орчинд амрах нөхцлийг бүрдүүлэх, учирч болзошгүй эрсдэл, гэмт хэргийг бууруулах, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх, ажил үйлчилгээ үзүүлж байгаа тухайн байгууллагын ажилчдад аамшгийн нөхцөл байдал үүссэн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах арга хэмжээг дадлага сургалтаар өгөх, тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Зохион байгуулах байгууллага

Нийслэлийн Онцгой байдлын газар, Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, "Эн Ар Ай" ХХК-ийн "Корпорейт хотел энд Конвэйшн центр" зочид буудал хамтран зохион байгуулан явуулна.

Гурав. Хамрагдах байгууллага, албан тушаалтан

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй одны зэрэглэлтэй зочид буудлын удирдлага, ерөнхий менежер, зохион байгуулагч, инженер техникийн албаны ажилтнууд хамрагдана.

Дөрөв. Дадлага сургууль явагдах газар, хугацаа

Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай "Эн Ар Ай" ХХК-ийн "Корпорейт хотел энд Конвэйшн центр"-ийн 16 давхар зочид буудлын барилга байгууламжид 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 09.00-16.00 цагийн хооронд зохион байгуулна.

Тав. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ


Д/д	Сургуулиар хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	Хариуцах албан тушаалтан
Бэлтгэл ажил				
1	Сургууль зохион байгуулагдах газар, хугацааг төлөвлөх, тухайн байгууллагын удирдлагатай ажлын уулзалт зохион байгуулах	2014.05.06-07-ны өдрүүдэд	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаа
2	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зэрэглэлтэй зочид буудлын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад зохион байгуулах сургуулийн төлөвлөгөөг хамтран боловсруулах, батлуулах	2014.05.08-09-ны өдрүүдэд	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаа
3	Дадлага сургууль явагдах Эн Ар Ай ХХК-ийн Конвэйшн центрийн 16 давхар зочид буудлын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах, зөрчил арилгуулах эрх зүйн баримт бичиг хүргүүлэх	2014.05.12-13-ны өдрүүдэд	Нийслэлийн Онцгой байдлын газар	Гал түймрийн улсын хяналтын чиглэлийн ахлах байцаагч онцгой байдлын ахмад С.Эрдэнэбаяр
4	Эн Ар Ай ХХК-ийн Конвэйшн центрийн 16 давхар зочид буудлын объекттой танилцах, зам гарцын судалгаа хийх, нөхцөл байдлыг тодорхойлох	2014.05.13-ны өдөр	Нийслэлийн Аврах анги Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Онцгой	Аврах шуурхай салбарын дарга онцгой байдлын ахлах дэслэгч Д.Батзориг Бүлгийн дарга нар Аврах гал унтраах 14 дүгээр ангийн захирагч онцгой байдлын дэд хурандаа Т.Баасанжав

			байдлын хэлтэс	Салааны захирагч нар
5	Тактикийн сургуулийн төлөвлөгөө болговсруулж хүн, хүч хэрэгслийн тооцоо, схем зураг гаргах, төлөвлөгөөг батлуулах	2014.05.13-15-ны өдрүүдэд	Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс	<p>Аврах гал унтраах 10 дугаар ангийн захирагч онцгой байдлын хурандаа Ч.Цогтбаяр</p> <p>Салааны захирагч нар</p> <p>Аврах гал унтраах 10 дугаар ангийн захирагч онцгой байдлын хурандаа Ч.Цогтбаяр</p> <p>Салааны захирагч нар</p> <p>Аврах гал унтраах 14 дүгээр ангийн захирагч онцгой байдлын дэд хурандаа Т.Баасанжав</p> <p>Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч онцгой байдлын ахмад Ж.Ганхүү</p> <p>Салааны захирагч нар</p>
Танхимын сургалт				
1	Зочид буудлын стандарт, аюулгүй байдлын шаардлагууд	2014.05.19-ний өдөр 09.00-09.30 цаг	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга ахлах мэргэжилтэн Д.Ганболд
2	Бэртэж гэмтсэн, түлэгдсэн, угаартсан иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, амилуулах суурь тусламж түүний үндсэн зарчмууд. /Дадлага/	2014.05.19-ний өдөр 09.30-10.30 цаг	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	<p>Үндэсний сургагч багш, НЯТТ төвийн дэд захирагч С.Ариунболд</p> <p>Үндэсний сургагч багш, НЯТТ төвийн хэмч. Тэгшжаргал</p>

3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь	2014.05.19-ний өдөр 10.30-11.30 цаг	Нийслэлийн Прокурорын газар	Улсын хяналтын прокурор Г.Бясман
4		Цайны цаг 11.30-12.00 цаг		
5	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар	2014.05.19-ний өдөр 12.00-13.00 цаг	Нийслэлийн Онцгой байдлын газар	Гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэлийн ахлах байцаагч онцгой байдлын дэд хурандаа Я.Жаргалсайхан
6	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар	2014.05.19-ний өдөр 13.00-14.00 цаг	Нийслэлийн Онцгой байдлын газар	Гал түймрийн улсын хяналтын чиглэлийн ахлах байцаагч онцгой байдлын ахмад С.Эрдэнэбаяр
Дадлага сургууль				
1	Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол гарсан дуудлагаар аврах, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг явуулах		Нийслэлийн Аврах анги	Аврах шуурхай салбарын хүн, хүч хэрэгсэл
2	Объектын гал түймрийг унтраах, аврах үйл ажиллагааг зохион байгуулах, өндөр барилгаас автомеханик шатны автомашин ашиглан иргэдийг аврах ажлыг явуулах	2014.05.19-ний өдөр 14.30-15.30 цаг	Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Аврах гал унтраах 10, 14 дүгээр ангийн хүн, хүч хэрэгсэл
3	Бэртэж гэмтсэн, түлэгдсэн, угаартсан иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах		Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Яаралтай түргэн тусламжийн төвийн хүн, хүч хэрэгсэл
4	Тэвшинд гал асааж тухайн байгууллагын ажилтан нараар гал унтраах дадлага сургуулийг зохион байгуулах	2014.05.19-ний өдөр 15.30-15.50	Нийслэлийн Онцгой байдлын газар	Урьдчилан сэргийлэх асуудал харьцсан мэргэжилтэн онцгой байдлын дэслэгч Г.Сэдэвдсүрэн
5	Дадлага сургуулийн явцын байдал, аврах, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа, гал түймрийг унтраах ажиллагааны талаар тайлбарлах	2014.05.19-ний өдөр 14.30-15.00	Нийслэлийн Онцгой байдлын газар	Урьдчилан сэргийлэх асуудал харьцсан мэргэжилтэн онцгой байдлын дэслэгч Г.Сэдэвдсүрэн

6	Сургуулийн явцын талаар иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргүүлэх ажлыг зохион байгуулах	2014.05.19-ний өдөр	Нийслэлийн Онцгой байдлын газар Нийслэлийн Аялал жуулчлалын газар	Хэвлэл мэдээлэл олон нийт хариуцсан мэргэжилтэн онцгой байдлын дэслэгч Х.Бурмаа Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаа
7	Хамтарсан дадлага сургуулийн зорилго, ач холбогдолын талаар төвч танилцуулга хийх	2014.05.19-ний өдөр 15.50-16.00	Нийслэлийн Онцгой байдлын газар	Орлогч дарга онцгой байдлын хурандаа Д.Эрдэнэбаатар

Нийслэлийн Онцгой байдлын газар, Аялал жуулчлалын газрын даргын 2011 оны 15 сарын 09-ний өдрийн А/26 тоот хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт



ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ТЕХНИКИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОСЛООС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ТӨСӨВ

1. Шатахууны зардал/нийслэлийн Онцгой байдлын газар/

д/д	Гал унтраах автомашин /улсын дугаар/	Шатахууны төрөл	100 км зарцуулах шатахуун /литр/	1 литр шатахууны үнэ	Явах зай /км/	1 мото/цаг т зарцуулах /литр/	Ажиллах цаг	Нийт шатахуун /литр/
1	10-р анги 3.5 тонн 20-86 УНБ	Дизель	40	1790	20	22	1	30
2	10-р анги 8 тонн 20-91 УНБ	Дизель	45	1790	20	22	1	31
3	10-р анги Автомеханик шат 06-81 УБЯ	Дизель	58	1790	20	40	1	51
4	14-р анги 3.5 тонн 06-55 УБЯ	Дизель	40	1790	36	22	1	38
5	14-р анги 8 тонн 06-64 УБЯ	Дизель	45	1790	36	22	1	40
6	Аврах анги 87-52 УНТ	АИ-92	18	1660	36	4.2	3	20
7	Аврах анги 01-05 УНО	Дизель	18	1790	36	-	-	7.2
Нийт						386,188 төгрөг		

2. Сургалтын бичлэг, хэвлэлтийн зардал/нийслэлийн Аялал жуулчлалын газар/

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Анонс /гал унтраах хүч хэрэгсэл байршуулсан/	6 м ²	1	15.000	90.000
2	Анонс /урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр/	1 м ²	2	28.000	56.000
3	Сургалтын бичлэг	40 минут	1	7500	300.000
Нийт дүн					446.000

3. Үзүүлэх сургалтын зардал /Нийслэлийн Аялал жуулчлалын газар/

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Гал унтраагуур /гал унтраах /	ш	4	40.000	160.000
2	Утаа гаргагч төхөөрөмж /шингэн/	1	5 литр	12.000	60.000
3	Түргэний машины шатахуун		1		20.000
4	Гал унтраах /дадлага/ Үзүүлэх сургалтад ашиглах шатахуун	Дизель	16	1790	28640
		АИ-80	10	1580	15800
Нийт үнэ					284.440

4. Нийт зардал

д/д	Зардлын нэр	Зардлын дүн
1	Шатахууны зардал	386,188 төгрөг
2	Сургалтын бичлэг, хэвлэлтийн зардал	446,000 төгрөг
3	Гал, унтраагуурын зардал	284,440 төгрөг
Бүгд		1,116,628 төгрөг

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НОБГ-ЫН АХЛАХ БАЙЦААГЧ, АХМАД

С.ЭРДЭНЭБАЯР

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Н.БАДАМХАНД

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА